



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 13

Хажуу шинэ ус

Шүхэрийн Мөнхцэцэгийг “Алтан гадас”  
одонгоор шагнуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар баталсан Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журмын 12-ын “Г”, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дах заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаас ТОГТООХ нь :

1.Тус сумын 3 дугаар багийн иргэн Шүхэрийн Мөнхцэцэгийн эрүүл мэндийн салбарт олон жил идэвхи зүтгэл, үр бүтээл гарган ажилласан хөдөлмөр бүтээлийг нь үнэлж Монгол Улсын төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнуулахаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай.

2.Тодорхойлолт материалыг аймгийн нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэхийг сумын Засаг дарга (Ө.Мөнх-Амгалан)-д үүрэг болгосугай.



ДАРГА *Ө.Мөнх-Амгалан* В.НЯМСҮРЭН



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 14

Хажуу шинэ ус

Сумын "соёлынбодлого"  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ :

1."Соёл урлагийг 2019-2023 онд хөгжүүлэх сумын бодлого"-ыг хавсралтаар баталсугай.

2. Сумын "соёлын бодлого"-ыг хэрэгжүүлэх жил жилийн төлөвлөгөө гаргаж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж хэрэгжилтийг хангаж ажиллах, бодлогын явц, үр дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр тайлагнаж байхыг сумын Засаг дарга (Ө.Мөнх-Амгалан)-д даалгасугай.

ДАРГА  В.НЯМСҮРЭН





ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 15

Хажуу шинэ ус

“Аз жаргалтай-Говь-Угтаал” дэд  
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дах заалт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ :

1.“Аз жаргалтай –Говь-Угтаал” дэд хөтөлбөрийг нэгдүгээр, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, хэрэгжилтийн тайлан үр дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд жил бүр тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Ө.Мөнх-Амгалан)-д даалгасугай.



ДАРГА

В.НЯМСҮРЭН



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 16

Хажуу шинэ ус

ИТХ-ын ээлжит 8 дугаар хуралдааны  
тов зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 8 дугаар хуралдааныг 2019 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн 09<sup>00</sup> цагт хуралдуулсугай.

2. Хуралдаанаар дараах үндсэн асуудлуудыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

1. Сумын 2018 оны төсвийн гүйцэтгэл, Аудитын дүгнэлт
2. Сумын ерөнхий төлөвлөгөөний танилцуулга
3. 2019 оны ОНХС-ын хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтад өөрчлөлт оруулах тухай
4. СХС-ын төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын тов тогтоох тухай
5. Тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох тухай

3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 8 дугаар хуралдаанаар хэлэлцэх асуудлыг чанартай бэлтгэж хуралдаанд оруулахыг сумын Засаг дарга (Ө.Мөнх-Амгалан)-т, хуралдааны бэлтгэлийг сайтар хангаж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Д. Жаргалмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА  В.НЯМСҮРЭН





ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 194

Хажуу шинэ ус

Эм эргэлтийн сангийн удирдах зөвлөлийн  
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаалыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1. Сумын эмийн эргэлтийн сангийн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн даргад	Ө.Мөнх-Амгалан /Сумын Засаг дарга/
Нарийн бичгийн даргад	Ж.Наранцацралт /ЭЭС-ын эрхлэгч/
Гишүүдэд	Г.Энхдэлгэр /Сум дундын эмнэлгийн дарга/ Б. Воля /иргэний төлөөлөл/ Х.Отгончимэг /2-р багийн эмч/ Ш.Мөнхцэцэг /Иргэний төлөөлөл/ Э.Уранбилэг /Төрийн сангийн төлөөлөгч/ Н.Угтахбаяр / Их эмч/ Б.Номин-Эрдэнэ /Сургуулийн нийгмийн ажилтан/

2.Эмийн эргэлтийн сангийн ажиллах журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг Зөвлөлийн дарга (Ө.Мөнх-Амгалан)-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 12 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  В.НЯМСҮРЭН





ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 18

Хажуу шинэ ус

Бүсчилсэн хөгжлийн бодлогын  
санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "Е" заалтыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн өргөтгөсөн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Үндэсний хөгжлийн газраас хэрэгжүүлж байгаа "Бүсчилсэн хөгжлийн бодлого" төсөлд тусгуулах Хөрөнгө оруулалтын төслийн саналыг 1 дүгээр хавсралтаар, Бодлогын баримт бичгийн саналыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгуулах хөрөнгө оруулалтын төсөл, бодлогын баримт бичгийн саналыг холбогдох материалын хамт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлж ажиллахыг Засаг дарга (Ө.Мөнх-Амгалан)-д үүрэг болгосугай.

ДАРГА  В.НЯМСҮРЭН

